



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Хатанбулаг сумын ЗДТГ-ын 2021 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын
хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2022/90/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Дорноговь аймаг 2022 он	Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий	
	Утас: 70522734	Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn
	Аудитын менежер: У.Оюунтүлхүүр	
	Утас: 70523020	Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn
	Ахлах аудитор: Э.Энхцэцэг	
		Цахим хаяг: enkhtsetsege@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (705) 2-27-34

Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

Дорноговь № 1-6/2021

танай _____-ны № _____-т

ДОРНОГОВЬ АЙМГИЙН
ХАТАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Т.ЦЭЦЭГСҮРЭН ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Хатанбулаг сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Хатанбулаг сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Хатанбулаг сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь бараа материалын мал амьтдын бүртгэлд 26.4 сая төгрөгийн 258 толгой мал бүртгэлд тусгагдсан байх боловч 2021.10.18-ны өдрийн тус байгууллагын няравт мал хүлээлцүүлсэн актад 1.7 сая төгрөгийн 99 толгой мал, жилийн эцсийн мал тооллогын дүнд 115 мал тоологдсон нь мал амьтны дансны үлдэгдлээс зөрүүтэй байна.

Сумын ОНХС-ийн хөрөнгөөр 2013 онд худалдан авч тус байгууллагад шилжүүлсэн 21.5 сая төгрөгийн шилмэл овгийн эцэг малыг малчдад гэрээгээр эзэмшүүлсэн гэх боловч гэрээ байгуулаагүйгээс эзэмшигч иргэн тодорхойгүй, СХС-аас малжуулах төслийн хүрээнд шилжүүлсэн малыг 2011 онд сумын ИТХ-ын "Эзэмшигч иргэдэд худалдах" тогтоолын дагуу борлуулж данснаас хасаж бүртгэсэн ба иргэн Т.Эрдэнэбаярт 3,2 сая төгрөгийн бүртгэлийн үнэтэй 106 толгой малыг борлуулсныг өнөөг хүртэл мөнгө нь тушаагдаагүй шалтгаанаар малын бүртгэлд үлдэгдэлтэй тайлагнасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар материаллаг буруу илэрхийллийн түвшнийг 26,1 сая төгрөгөөр тогтоосон. Гэвч нийт илэрсэн алдаа, зөрчил нь тогтоосон материаллаг буруу илэрхийллийн түвшнээс бага байгаа боловч 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгагдсан 26.4 сая төгрөгийн мал амьтдын үлдэгдлийн үнэн зөв, бодитой эсэхийг аудитын явцад нотлох боломжгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-д "Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн үнэн зөв байх зарчмыг баримтална", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "Ерөнхий нягтлан бодогч нь эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах үүрэг хүлээнэ" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт-1, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.ГАН-ӨЛЗИЙ

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/төгрөгөөр/	
	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	<u>81,254,232.28</u>	<u>87,427,391.54</u>
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	<u>2,514,279,277.11</u>	<u>2,685,278,528.90</u>
	Нийт хөрөнгийн дүн	<u>2,595,533,509.39</u>	<u>2,772,705,920.44</u>
	Нийт өр төлбөрийн дүн	<u>431,540.00</u>	<u>90.00</u>
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	<u>2,595,101,969.39</u>	<u>2,772,705,830.44</u>
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	<u>2,595,533,509.39</u>	<u>2,772,705,920.44</u>
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	1,269,072,476.50	1,197,319,870.21
	Үйл ажиллагааны зардлын дүн	822,559,351.71	1,001,061,590.30
	Үйл ажиллагааны үр дүн	<u>446,513,124.79</u>	<u>196,258,279.91</u>
	Үйл ажиллагааны бус үр дүн		(18,654,418.86)
	Үйл ажиллагааны нийт үр дүн	<u>446,513,124.79</u>	<u>177,603,861.05</u>
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,514,989,636.59	2,595,101,969.39
	Тайлант оны үр дүн		177,603,861.05
	Эцсийн үлдэгдэл	1,514,989,636.59	2,772,705,830.44
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	<u>645,949,243.63</u>	<u>968,511,170.25</u>
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	<u>602,549,243.63</u>	<u>709,148,942.25</u>
	Үйл ажиллагааны ЦМГ	<u>43,400,000.00</u>	<u>259,362,228.00</u>
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	<u>(43,400,000.00)</u>	<u>(259,362,228.00)</u>
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ		
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн		477,723,548.25
	Урсгал зардал		477,723,548.25
	Хөрөнгийн зардал		
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр		477,723,548.25
	Улсын төсвөөс санхүүжих		469,623,998.25
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас		8,099,550.00

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дорноговь аймгийн Хатанбулаг сумын ЗДТГ-ын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлсон байна.

Нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, хөтөлбөр, төсөл зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, бодлогын удирдамжаар хангах, төрийн үйлчилгээг хүргэх, Засаг даргаас бүрэн эрхээ хэрэгжүүлэх, нутгийн захиргааны байгууллагыг чиглүүлэн удирдахад нь зохион байгуулалт, эрх зүй, аж ахуйн үйлчилгээгээр туслах.

Эрхэм зорилго: Албан хаагчдын эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлж, өсөж дэвших, боломжийг хангах, хэрэглэгчдийн шаардлагад нийцсэн төрийн үйлчилгээг үзүүлэх.

Алсын хараа: Нутгийн захиргааны тэргүүлэгч байгууллага болох.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

Ковид-19 цар тахал өвчинтэй холбоотой засгийн газрын тогтоол, шийдвэрүүд шинээр гарч хэрэгжсэн.

ГУРАВ. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант хугацаанд Хатанбулаг сумын ЗДТГ-ын нягтлан бодох бүртгэл хөтлөх, удирдан зохион байгуулах чиг үүрэг бүхий нягтлан бодогчийн албан тушаалд 4 ажилтан өөрчлөгдөн томилогдож ажилласан байна.

Дөрөв. Аудитын гол асуудал

Тайлант хугацаанд тус сумын 23 иргэнтэй орон сууц түрээслүүлэх гэрээ байгуулж, 2021 онд нийт 11.9 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээс 10.0 сая төгрөгийг төвлөрүүлж, дутуу төвлөрүүлсэн 1.9 сая төгрөгийн түрээсийн орлогыг санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй, мөн орон нутагт төвлөрүүлэх 50 хувийн төлбөр 5.0 сая төгрөгөөс 2.9 сая төгрөгийг төвлөрүүлж, дутуу 2.1 сая төгрөгийг өглөгөөр тайлагнаагүй байна. Түрээсийн орлогын тооцоог тухай бүр хийдэггүйгээс тус зөрчил жил бүр давтагдан гарсан байна.

Тайлант хугацааны эцэст Энх-Агаруут ХХК, иргэн Д.Азжаргал нараас 4.8 сая төгрөгийн сэлбэг хэрэгсэл худалдан авч бараа материалын холбогдох дансанд орлогоор бүртгэсэн байх боловч сэлбэг хэрэгслийг бодитоор хүлээн аваагүй, сэлбэг хэрэгслийн үлдэгдлийн дүнг нэмэгдүүлж тайлагнасан байна.

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс өгсөн 8.3 сая төгрөгийн хандивын орлогыг нэмэлтийн дансанд төвлөрүүлж, зарцуулсан байна.

Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс 9 мэдээллийг хоцроож, 140 мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн байна.

Цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 648.2 сая төгрөгийн 23 ажил гүйлгээнээс 139.2 сая төгрөгийн 8, орлогын 1061.8 сая төгрөгийн 41 ажил гүйлгээнээс 417.8 сая төгрөгийн 12 ажил гүйлгээг, хөрөнгө зарцуулах тухай 19 тушаалаас 15 тушаалыг мэдээлээгүй байна.

Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

Долоо. Аудитын илрүүлэлт:

. Аудитаар нийт 26.7 сая төгрөгийн 8 алдаа, зөрчил илрүүлснээс, 4.2 сая төгрөгийн 1 алдааг залруулж, 4.3 сая төгрөгийн 2 төлбөрийн акт, 13.4 сая төгрөгийн 4 албан шаардлага өгч, 4.8 сая төгрөгийн 1 зөвлөмж хүргүүлээ.

Залруулсан алдаа:

Тайлант хугацаанд нийт 19.7 сая төгрөгийн өвс тэжээлийн орлого, 24.8 сая төгрөгийн зарлага бүртгэж тайлагнасан байх ба 56 малчин өрхөд 4.2 сая төгрөгийн өвс зээлээр өгч, тусгай зориулалттай материалд үлдэгдлээр тайлагнасныг авлагаар тусгаж залруулав.

Төлбөрийн акт:

1. Тайлант хугацаанд тус сумын 23 иргэнтэй орон сууц түрээслүүлэх гэрээ байгуулж, 2021 онд нийт 11.9 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээс 10.0 сая төгрөгийг төвлөрүүлж, дутуу төвлөрүүлсэн 1.9 сая төгрөгийн түрээсийн орлогыг санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй, мөн тус орлогын орон нутагт төвлөрүүлэх 50 хувь болох 5.0 сая төгрөгөөс 2.9 сая төгрөгийг төвлөрүүлж, төвлөрүүлээгүй 2.1 сая төгрөгийг өглөгөөр тусгаж тайлагнаагүй байсан зөрчилд төлбөрийн акт тогтоов.

2. Засаг даргын нөөц сангаас нийт 32.9 сая төгрөгийг зарцуулснаас сумын ЗД-ын 2021.09.24-ний өдрийн А/131 захирамжаар аймгийн ОБГ-ын албан хаагчдын буудал, хоолны зардалд 0,3 сая төгрөгийг зарцуулсан зөрчилд төлбөрийн акт тогтоов.байна.

Албан шаардлага:

1. Бараа материал дахь мал амьтдын дансанд нийт 258 толгой мал бүртгэлтэй байгаагаас 53 эцэг мал, СХС-ийн гэх 106, нас хүйс нь тодорхой бус 99 мал байх ба нярав 83 эм малын нас дэвшилтийг бүртгэж тайлагнаагүй, эцэг малыг малчдад ашиглуулж байгаа талаар бүртгэл, гэрээ байхгүй, 3.2 сая төгрөгийн үнэтэй 106 толгой мал ЗДТГ-ын дансанд бүртгэлтэй боловч бодитоор байхгүй байна. Мөн малын үнэ ханшийг зах зээлийн үнэтэй уялдуулж тогтоогоогүй байна.

- Мал амьтдын дансанд бүртгэлтэй 53 эцэг малыг ашиглаж байгаа малчидтай гэрээ байгуулах, нас дэвшилтийг бүртгэж тайлагнах, малын үнэ ханшийг зах зээлийн үнэтэй уялдуулж тогтоох, ЗДТГ-ын дансанд бүртгэлтэй боловч бодитоор байхгүй байгаа 3.2 сая төгрөгийн үнэтэй 106 толгой малын асуудлыг холбогдох газарт уламжилж шийдвэрлүүлэх талаар албан шаардлага өгөв.

2. Цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 648.2 сая төгрөгийн 23 ажил гүйлгээ гарснаас 139.2 сая төгрөгийн, орлогын 1061.8 сая төгрөгийн 41 ажил гүйлгээнээс 417.8 сая төгрөгийн ажил гүйлгээг, хөрөнгө зарцуулах тухай 19 тушаалаас 15 тушаалыг мэдээлээгүй байна.

- Мэдээллийг нөхөн байршуулах, хугацаандаа байршуулах, цаашид хугацаа хоцроох, мэдээллийг байршуулахгүй байх зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөв.

3. Мөнгөн гүйлгээний тайланд тусгагдсан зардлуудыг ангилал тус бүрээр мөнгөн гүйлгээний журналаас түүвэрлэж, холбогдох анхан шатны баримтаас тулгаж үзэхэд 1.9 сая төгрөгийн зардлыг зардал хооронд шилжүүлэн зарцуулж, зориулалт бусаар зарцуулсан байна.

- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан зааврын дагуу батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах тухай албан шаардлага хүргүүлэв.

4. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс өгсөн 8.3 сая төгрөгийн хандивын орлогыг нэмэлтийн дансанд төвлөрүүлж, зарцуулсан байна.

- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 “Албан тушаалтан, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага нийтийн хэрэгцээнд зориулан иргэн, хуулийн этгээдээс бэлэг, бусад санхүүгийн туслалцааг авах, хүсэхийг хориглоно” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах талаар албан шаардлага хүргүүлэв.

Зөвлөмж:

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бараа материалын ангитай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Тайлант хугацааны эцэст Энх-Агариут ХХК, иргэн Д.Азжаргал нараас 4.8 сая төгрөгийн сэлбэг хэрэгсэл худалдан авч бараа материалд орлогоор бүртгэсэн байх боловч сэлбэг хэрэгслийг бодитоор хүлээн аваагүй, үлдэгдлийн дүнг нэмэгдүүлж тайлагнасан байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 “Ерөнхий нягтлан бодогч нь холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах үүрэгтэй” гэсэн заалтын дагуу бараа материалын тайланг хянаж, үнэн зөв тайлагнах.

8.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	Хатанбулаг сумын ЗДТГ	1	1	-	-	-	1	-	-
НИЙТ									

8.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	Хатанбулаг сумын ЗДТГ	8	26.7	1	4.2	2	4.3	4	13.4	1	4.8
НИЙТ		8	26.7	1	4.2	2	4.3	4	13.4	1	4.8